

МОНГОЛ-ХЯГАДЫН ХИЛИЙН ТӨМӨР ЗАМЫН  
Х Э Л Э Л Ц Э Э Р.

1956 оны 1 дүгээр сарын нэгнээс  
хүчин төгөлдөр болно.

## МОНГОЛ-ХЯТАДЫН ХИЛИЙН ТӨМӨР ЗАМЫН

### Х Э Л Э Л Ц Э Э Р.

Нэг талаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Тээврийн Яам / Б.Н.М.А.У./ ба нөгөө талаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын / Б.Н.Х.У./ Төмөр Замын Яамыг төлөөлөгчид, Хилийн төмөр замын дор дурдсан хэлэлцээрийг байгуулав, үүнд :

#### 1. Хилийн станцууд.

§ 1. Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төмөр замуудын хоорондох хилийн станцуудыг тогтоох нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төмөр замын талд	Улсын хил хүртэлх зай км - э э р	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төмөр замын талд	Улсын хил хүртэлх зай км - зар-
Замын - Үүд	4,5	Эрлянь	4.8

Хоёр чиглэлд явах байгаа, вагонууд ба ачаануудыг шилжүүлэх ажиллагааг Эрлянь станц дээр гүйцэтгэнэ. Замын-Үүдийн станц дээр эдгээр ажиллагаа хийгдэхгүй болно.

Б.Н.М.А.Улсаас Б.Н.Х.А.Улсад очих ССРС-ээс Б.Н.Х.А.Улсад очих буруу эсрэг чиглэлд явах байгаа вагонуудыг өөр царигт дугуйн хос / тэргэнцэр / дээр шилжүүлэн тавих, тэрчлэн ачаануудыг шилжүүлэн ачих ажиллагааг Б.Н.Х.А.Улсын төмөр замын Зинин станц дээр гүйцэтгэнэ.

Хилийн станцууд ба тэдний хоорондын замын техникзүүлэлт нь хоёр талын төмөр замын галт тэргийг нөгөө талын хилийн станц хүртэл саадгүй нэвтрүүлж чадахуйц байвал зохино.

Б.Н.М.А.Улсаас Б.Н.Х.А.Улсад очих ба СССР-ээс Б.Н.Х.А.Улсал очих болон буцах чиглэлд явж байгаа хөдлөх бүрэлдэхүүн ба ачаануудыг хүлээн авах хийгээд хүлээлгэн өх явдлыг Эрлянз станцийн техник зүүлэлт нь саадгүй хангахуйц байвал зохино.

Шилжүүлэн ачих Зинин станц нь ачаануудыг шилжүүлэн ачих,суудлын ба ачааны вагонуудыг шилжүүлэн тавих,төрчлөн 1524,1435 мм-ийн өргөн царигт вагонуудыг пүүлж вагоны пүү зэрэг зайналгүй шаардагдах байгууламж ба төхөөрөгүүдтэй байвал зохино.

## II. Галт тэрэгнүүдийн хөдөлгөөний нөхцлүүд.

§ 2.1. Хилийн станцуудын хооронд хүмүүс ба ачаа тээвэрлэх явдлыг энэ хэлэлцээрийн 1-р хавсралтад заасан галт тэрэгний хөдөлгөөний дүрэм ёсоор шилжүүлэх галт тэргүүдээр гүйцэтгэнэ.

2. Хилийн станцуудын хоорондын замд галт тэргүүд ба түүнчлэн олон улсын шууд харилцааны суудлын галт тэргийг хоёр чиглэлд үйлчлэх явдлыг заавал Б.Н.М.А.Улсын төмөр замын локомотив, локомотивын ба галт тэрэгний бригадууд гүйцэтгэнэ. Харин зарим үест хоёр тал харилцан тохиролцож, шилжүүлэх галт тэргүүдийг үйлчлүүлэх явдалд Хятадын локо-

мотив, галт тэрэг ба локомотивын бригадуудыг ашиглаж болох юм.

Суудлын галт тэргүүд, тэрчлэн олон улсын харилцааны зарим суудлын вагонуудыг явах бүх замын туршид тэдгээр вагонуудыг эзэмшигч замын галт тэрэгний дарга нар, вагоны үйлчлэгчид ба бусад хүмүүс үйлчлэнэ.

3. СМГС ба СМПС-ны тооцоо үйлдэх дүрмийн 14-р маягтаар бүртгэгддэг, гүйцэтгэсэн вагон-гол-километрийн тооцоог энэ дүрмийн §38-д зааснаар үйлдэнэ.

Улсын хилээс нөгөө талын хилийн станци хүртэлх хэсэгт галт тэргүүдийг үйлчилсний хөлсийг вагон-гол километр дутам 0,07 рублээр бодож тооцоолно.

Халхлалт болгох буруу тормозын барилтыг хангах зорилгоор галт тэргэнд оруулсан хоосон вагонууд, тэрчлэн хүлээн аваагүй вагонуудын явсны хөлсийг төлөхгүй.

4. Хил дахь хоорондын замаар, шилжүүлэх галт тэрэгний хөдөлгөөнийг хоёр талын хилийн төмөр замын хэрэг эрхлэх газруудын харилцан тохиролцсон цагийн хувиар ба график ёсоор явуулна.

5. Галт тэрэгнүүдийн хөдөлгөөний цагийн хувиарт байвал зохих агуулгууд:

- а/ Галт тэрэгнүүдийн дугаар ;
- б/ Хилийн станцуудын хоорондох замд галт тэргийг үйлчлэгч, локомотивуудын сери ;
- в/ Галт тэрэгний / савтай / жин ;
- г/ Локомотивгүй галт тэрэгний урт / голоор /;
- д/ Галт тэрэг ба ганцаар явах локомотивуудын хөдөлгөөнд зөвшөөрөгдөх хамгийн их хурд ;

е/ Хилийн станцуудын хоорондын замд галт тэрэг явах хугацаа ;

ж/ Заавал байх ажиллагаатай тормозын тоо ;  
Эдгээр болно.

6. Хоёр талын хилийн постуудын дэргэд зогсох суудлын ба ачааны галт тэрэгнүүдийн зогсолтыг цагийн хувиарт заасан байвал зохино.

7. Ачааны галт тэрэгнүүдийн цагийн хувиарыг зохиоходоо, Улаанбаатар төмөр замын локомотивын ба галт тэрэгний бригад нь Эрлян станци дээр заавал гүйцэтгэх техникийн ажиллагааг дуусмагц буцах чиглэлийн галт тэргийг үйлчилж чадахаар бодолцсон байвал зохино.

8. Хилийн станцуудын хооронд галт тэргүүд ба ганцаар явах локомотивуудын хөдөлгөөнийг цахилгаан жезлийн системээр үйлдэнэ.

9. Хөдөлгөөний графикт заагдсан галт тэрэгнүүдийг өөрчлөх ба галт тэрэг нэмж явуулах тухай мэдээг галт тэргийг явуулахаас 6 цагийн өмнө хилийн нэг станци нь нөгөөдөө мэдэгднэ.

10. Тэнхрүүлэх галт тэрэг ба цас цэвэрлэгчээс бусад албаны ба сухиа галт тэргийг тухай бүрд нь хоёр талын хилийн төмөр замын хэрэг эрхлэх газар хоорондоо тусгай тохиролцоо явуулна.

III. Тээвэрлэлтийг төлөвлөх ба вагон шилжүүлэх тухай мэдээ солилцох хурам.

§ 3.1. Б Н И А Улсын төмөр замын яам нь / ачилтын урьдчилсан мэдээгээр / сар эхэлэхээс

6 өдрийн өмнө, Б Н М А Улсын Тээврийн Яам нь /өөрийн ажилт ба СССР-ийн төмөр замуудаас авсан мэдээгээр / сар эхлэхээс 4 өдрийн өмнө телеграфтар Замын-Үүд ба Эрляний чиглэлээр ирэх сард ашигдах хоногийн дундач хэмжээг тонн ба вагоноор зааж нийт ачааны тоог дурьдсан мэдээг харилцан хоорондоо солилцох байна, үүнээс : хүдэр ; нүүрс ; үр тариа ; цемент, тунгалаг ба бүдэг шингэн ачаа, хялбар гэмтэх мах хийслэг ачааг тусад нь ; үйлдвэрийн тоноглол ; авто машинуудыг ялгах заана.

2. Хилийн Замын-Үүд ба Эрлянь станц хоёр Бээжингийн цагаар 15 цагийн өмнө явагдах байгаа өдрийн 17 цагаас эхлэн дараагийн хоногт нэг станцаас нөгөөдөө галт тэрэг явуулах тухай мэдээг хоорондоо солилцно.

Мэдээнд галт тэргүүд ба вагонуудын тоо, үүнээс ачаатай ба хоосон вагонуудыг заасан байвал зохино, гэхдээ хоосон вагоны төрөл, галт тэрэгний номер, тунгалаг буюу бүдэг шингэн ачаа, өвөргүй буюу хялбар гэмтэх ба осолтой ачаануудыг тус тус заана.

Ирэх хагас хоногийн мэдээг Бээжингийн цагаар 18 ба 6 цагт телеграфтар тус тус лавлан шалгана. Хагас хоногийн мэдээг 6 цаг дутам лавлах байна.

3. Замын-Үүд ба Эрлянь станц хоёр нэгээс нөгөөдөө явуулах галт тэрэгний тухай зөв мэдээг галт тэрэгний бүрэлдхүүн бэлэн болсноос хойш нэг цагийн дотор телефоноор солилцох бөгөөд түүндээ галт

төрөгний дугаар, ачаатай ба хоосон вагоны төрөл ба тоо, осолтой, хялбар гэмтэх, шингэн ачаа/бүдэг тунгалаг/ оворгүй ачааг заана.

4. Хилийн төмөр замын хэрэг эрхлэх газрууд бэлэн байгаа ачаатай ба хоосон вагон, тэдгээрийн төрлийн тухай мэдээг бие биедээ өдөр бүр 19 цагийн өмнө телеграфтаар мэдээлэлцэж байх бөгөөд Б.Н.Х.А.Улсад зориулж Сүхбаатараас Замын-Үүд хүртэлх хэсгийн мэдээг 17 цаг, Б.Н.М.А.Улсад зориулж Зининээс Эрлянх хүртэлх хэсгийн мэдээг 18 цагийн байдлаар тус тус гаргаж байна.

#### Ү1. Телеграф ба телефон холбоо.

§ 4. 1. Хилийн станцуудын хооронд албан хэрэгцээнд зориулж телеграфын ба телефон холбоотогтооно. Хоёр талын телеграфын аппарат нь морзын системтэй байвал зохино.

Телеграфын шугам нь улсын дотоодын холбоотой залгагдаагүй, тусгай аппаратуудаар дуусна.

Хилийн станцууд дахь телефон шугам нь телефон аппаратаар дуусна.

Олон улсын тээвэрлэлттэй холбогдох ажиллагааны асуудлуудаар албан яриа явуулахын тул эдгээр телефон аппаратууд нь төмөр замуудын дотоодын телефон станцуудтай, холбох, хэрэглэлээр тоноглогдсон байвал зохино.

2. Хилийн станцаас улсын хил дахь телеграф-телефоны шалгах шон хүртэл өөрийн хилийн дотор телеграфын ба телефон аппаратууд тавих,

залгах, утаснуудыг татах, засварлах, холбооны төхөөр-  
гийн үйлчлэлтийг өөр өөрсдийн төмөр замын захирал  
ба хөрөнгөөр гүйцэтгэгдэнэ.

3. Телеграфын ба телефон шугамуудыг техни-  
кийн талаар зөв үйлчлэх явдлыг хангах болон шугам  
гэмтвэл гэмтэлтэй хэсгийг цаг тухайд нь олох зори-  
лгоор хоёр талын улсын хил дээр бүх утаснуудыг  
шалгах төхөөрөмжөөр тоноглогдсон телеграфын-теле-  
фоны шалгах шонг байгуулна.

Өөрсдийн нутагт шалгах төхөөрөмжийг эвлүүлж  
байгуулсаны зардлыг хоёр тал өөрсдөө харуцна.

Хилийн телеграф ба телефон утасны шалгах  
шонгийн хоорондох телеграфын утаснуудыг Б.Н.М.А.  
Улсын төмөр зам арчлах ба, харин телефон утасны  
шугамыг Б.Н.Х.А. Улс арчлана.

4. Хилийн станцуудын хооронд телеграфын ба  
телефон харилцааны шугамууд гэмтвэл түүнийг илэр-  
үүлсэн тал нь нөгөө талдаа яаралтай мэдэгдэнэ.  
Үүний дараагаар хоёр тал нь улсын хил дахь теле-  
граф-телефоны шалгах шон хүртэл үйлчилж байгаа  
шугамууддаа шалгах засах ажлыг яаралтай хийж эхэлнэ

Ү. Хилийн станцууд ба тэдний  
хоорондын замд баримтлах  
ц а г.

---

§ 5.1. Хилийн станцууд ба тэдний хоорондын  
замд, галт төрөгний хөдөлгөөнтэй холбогдсон, бүх  
ажиллагаа, төрчлэн вагонууд, тээш, бараа- тээш ба

ачаануудыг шилжүүлэхэд 24 цагт Бээжингийн цагийг хэрэглэнэ.

2. Б.Н.Х.А.Улсын төмөр замын хилийн Эрлян станц нь Б.Н.М.А.Улсын хилийн Замын-Үүд станцад өдөр бүрийн 12 цагт цагаа шалгаж нийлэхийн тулд Бээжингийн зөв цагийг телеграфаар мэдэгдэнэ.

3. Тайлант хоногийг Бээжингийн цагаар 17 цаг 00 минутад эхэлж байна.

У1. Хилийн станцууд дээрх албан тасалгаанууд ,станцийн ба замын төхөөргүүдийг ашиглах нөхцөл , журам.

---

§ 6,1. Хилийн станцууд дээр байгаа усаар хангах төхөөрөмж, эргүүлэх тойрог, эргүүлдэг гурвалжин ба вагоны пүүг нөгөө тал нь үнэ төлбөргүй ашиглах эрхтэй.

2. Хилийн Эрлян станц ба шилжүүлэн ачих Зинин станц дээр байгаа 1524 мм-ийн царигт ачааны вагонуудыг пүүлдэг вагоны пүүнүүдийг Б.Н.М.А.Улсын төмөр замын, пүү шалгах-платформоор жилд хоёроос доошгүй удаа шалгаж 3-р хавсралтын маягтаар шалгасан акт бичнэ.

Вагоны пүүнүүдийг шалгах зорилгоор пүү шалгах платформыг Зинин станц дээр анханы 4 өдөр, Эрлян станц дээр анханы 2 өдөр, ашигласаны хөлсийг Б.Н.М.А.Улсын төмөр зам нь бичихгүй. Платформ ашигласан дараачийн өдрүүдэд ашигласан хоног дутамд түүний голын тоог үл харгалзан 20,3 рублийн

хэмжээтэй хөлсийг бичнэ. Дутуу хоног ашигласныг бүтэн хоногт тоолно.

§ 7. Вагонууд ба ачаануудыг шилжүүлэх талаар үүрэг гүйцэтгэж байгаа, Монголын талын агентуудад, Хятадын тал нь Эрлянь станц дээр ажиллах ба амрахад зохицуулан бэлтгэсэн өрөө тасалгааг үнэ төлбөргүй гаргах өгнө. Эдгээр өрөө тасалгааг эзэмшигчийн зардал, хөрөнгөөр цэвэрлэж, гэрэлтүүлж галлаж байна.

§ 8. Б.Н.М.А. Улсын төмөр замын техникийн ба тээврийн агентууд нь Эрлянь станц дээр ажиллах байхдаа өөрийн талын хилийн станцтай албан хэргээр ярих явдалд телеграф ба телефон харилцааг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй болно.

§ 9. Шилжүүлэх ажиллагааг Замын-Үүдийн станц дээр нээх үед, төхөөрөг ба өрөө тасалгааны талаар Монголын тал Эрлянь станц дээр эдэлж байсан эрхийг Хятадын тал нь Замын-Үүдийн станц дээр мөн адил эдэлнэ.

ҮШ. Нөгөө талын дэвсгэр нутагт  
төмөр замын хүмүүс байх  
т у х а й.

§ 10. Б.Н.М.А. Улс ба Б.Н.Х.А. Улсын хоорондох харилцаанд тээш ба бараа-тээш тэрчлэн вагонууд болон ачаанууд, галт тэрэгнүүдийг хүлээн авах ба хүлээлгэн өх ажиллагаануудыг хангах, зорьчигчдыг үйлчлэхийн тулд Б.Н.М.А. Улсын төмөр зам нь хилийн Эрлянь станц дээр, төмөр замын техникийн ба бусад

заавал шаардагдах агентуудыг байлгах эрхтэй.

Замын-Үүдийн станц дээр шилжүүлэх ажиллагаа нээгдвэл Хятадын тал түүнийг адил эрх олгогдно.

§11. Төмөр замын төхөөргүүд ба хөдлөх бүрэлдэхүүнийг арчлах, засварлах буюу сэргээх тэнхэрүүлэх азлыг гүйцэтгэх болон гэмтэл тохиолдсон явдлыг шалгах комисст оролцох, эсхүүд өөрийн агентуудын ажиллагааг шалгах үүргийг гүйцэтгүүлэхийн тулд нэг тал нь нөгөө талын нутаг дэвсгэр дахь хилийн станц ба түүний хоорондын замд галт тэрэгний бригадуудаас гадна 5-аас илүүгүй хүмүүсийг шилжүүлэх галт тэрэгнүүдээр явуулах эрхтэй.

Төмөр замын хүмүүс нөгөө талын төмөр замд хүрэлцэн очиж байхдаа тэр талын хууль дүрэмд захирагдна.

Хоёр талын хилийн станцуудын хооронд нэвтрэлцэх ба нөгөө талын нутагт хүрэлцэн очиж байх дүрмийг 2-р хавсралтанд дурьдсан болно.

§12. Нөгөө талын дэвсгэр нутагт төмөр замын хүмүүс хүрэлцэн очиж албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах тусламцааг үзүүлнэ.

§13. Нөгөө талын дэвсгэр нутагт байгаа төмөр замын хүмүүс гэмт өвдөх, бэртэх, шархдах үест тэдэнд үнэ төлбөргүй эмнэлэгийн тусламж үзүүлнэ.

#### ҮШ. Галт тэрэгнүүдийг үйлчлэх журам.

§14. 1. Галт тэрэг үйлчилж яваа докментийн ба галт тэрэгний бригад нь явж байгаа төмөр замын

техник ашиглалтын дүрэм, галт тэрэгний хөдөлгөөний ба дохионы заавруудыг мөрдөн биелүүлж тэр тэмэр замын албан захирамжийг дагаж гүйцэтгэх үүрэгтэй. Хэлэлцэгч хоёр тал энэ зорилгоор дүрэм, заавруудаа солилцно.

2. Галт тэрэг явж байхад түүний албан хаагчид нь өөрийн ерөнхий кондуктортоо захирагдана.

3. Нөгөө талын галт тэрэгний бригадад өх бичмөл захирамжийг хоёр талын албан ёсны хэл дээр бичнэ.

§15. Галт тэрэгнүүдийн гаднын хамгаалалтыг эдгээр галт тэрэгнүүд явж байгаа, төмөр замын тал хариуцна. Галт тэргэнд байгаа ачаа ба вагонуудын техникийн байдлыг эдгээр вагонуудыг хүлээн авах талд хүлээлгэн өгч гүйцэх хүртэл галт тэргийг хүргэж ирсэн галт тэрэгний бригад хариуцна.

§16. Нөгөө талын төмөр замд локомотив очиж байх хугацаанд техникийн байдлыг тэр локомотивтай хүрэлцэн очсон локомотивын бригад хариуцна.

§17. Хилийн станцуудын хооронд ганц локомотиваар явах эрхийг 2-р хавсралтын 1-р зүйлд заагдсан хүмүүс эдэлнэ.

Локомотивын бригадаас гадна уг локомотив дээр 4-өөс илүүгүй хүмүүс явж болно.

§18. 1. Хилийн станцуудын хооронд локомотив нь галт тэрэгний толгойд явна. Галт тэрэг буюу

ганцаараа яваа локомотивууд улсын хилд ойртон очоод галт тэрэг / ганцаар яваа локомотив / гарч байгаа талын гаалийн ба хилийн хянагч нарыг буулгахын тулд үзэгдэх дохионы дэргэд зогсно.

Галт тэрэг буюу ганцаараа яваа локомотивууд нь улсын хилийг нэвтрэн гарсаны дараа галт тэрэг / ганцаар яваа локомотив / хүрэлцэн очсон талын гаалийн ба хилийн хянагч нарыг суулгахын тулд үзэгдэх дохионы дэргэд дээрхийн адил зогсно.

Хилийн ба гаалийн хяналт буюу техникийн байдалд үл хамаарагдах шалтгаанаар улсын хил ба хилийн станцуудын хооронд галт тэрэгнүүдийг зогсоох ба тогтоосон хурдыг багасгах явдлыг хориглоно.

2. Б.Н.М.А.Улс ба Б.Н.Х.А.Улсын талд улсын хил дээр галт тэрэг зогсоох газруудад зогсоох дохио-улаан диск тавина.

Хоногийн харанхуй хугацаанд ба алсын бараа муу харагдах үед эдгээр дискууд нь улаан гэрэлтэй байна.

3. Эдгээр дохиог тавих газрыг хоёр талын хилийн төмөр замын хэрэг эрхлэх газруудын төлөөлөгчдөөс бүрдсэн комиссоос тогтооно.

4. Улсын хилийн дэргэд хил хянагч хүмүүсийг буулгах ба суулгахаар зогссоны дараа галт тэргийг ерөнхий кондукторын дохиогоор явуулна, харин локомотивыг ганцаар явуулах үест хүмүүсийг суулгах ба буулгах ажил дууссан гэх

хил хянагчдын ажлагчаас мэдэгдсэний дараа локомотивын шүгэл дохиогоор хөдлөн явна.

§19. Б.Н.М.А.Улсын төмөр замаар нэвтрүүлэн өнгөрүүлж СССР-ба Б.Н.Х.А.Улсуудын хооронд ачаа тээвэрлэх хоосон вагонуудыг СССР-ийн төмөр замаас хангах журам ба СССР-ийн төмөр замын вагонуудыг ашиглах журмыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төмөр замаар нэвтрүүлэн өнгөрүүлж Зөвлөлт Холбоот Улс ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсуудын хооронд төмөр замын шууд харилцаа нээх явдалд холбогдох асуудлуудын талаар Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Холбоот Улс ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсуудын төмөр замын төлөөлөгчдийн Бага Хурлаас гаргасан протоколоор тогтооно.

§20. Шилжүүлэх галт тэрэгнүүдийг үйлчилж байгаа Б.Н.М.А.Улсын төмөр зам нь, Галт тэрэгний хөдөлгөөний тохиролцсон график ёсоор локомотивууд, локомотивын ба галт тэрэгний бригадуудаар хангах үүрэгтэй.

Б.Н.Х.А.Улсын төмөр зам нь, хэрэгцээ тохиолдвол нэмэлт локомотив ирүүлэхийг шилжүүлэх галт тэрэг үйлчлэх талаас шаардах ёрхтэй.

Энэ үед Б.Н.М.А.Улсын төмөр зам нь захиалга авсанаас хойш 4 цагаас хэтрүүлэлгүй локомотив ба галт тэрэгний бригад явуулах үүрэгтэй.

Локомотив ба галт тэрэгний бригад ирүүлэх тухай захиалгыг телеграф буюу телефонграммаар өгнө.

Энэ захиалгад вагоны тоо, галт тэрэгний хин, галт тэргийг Эрлян станцаас илгээх ба локомотивыг Замын-Үүд станцаас илгээх цагуудыг заасан байвал зохино.

Шилжүүлэх галт тэргийг үйлчилж байгаа Б.Н. М.А.Улсын төмөр замын локомотивууд нь галт тэрэгний бригадын хамтаар локомотивуудын эргэх график ёсоор галт тэрэгтэй бууу ганцаараа буцсан байвал зохино.

### 1X. Маневрын ажил.

§21. Хилийн Эрлян станц дээр шилжүүлэх галт тэрэгнүүдийн маневрын ажлыг Б.Н.Х.А.Улсын төмөр зам өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ. Хэрэв хэрэгцээ тохиолдвол Б.Н.Х.А.Улсын төмөр замын захиалгаар, Б.Н.М.А.Улс нь түлш ба материалтай нь, бригадын хамтаар өөрийн маневрын локомотивыг өгнө. Локомотив өх бололцоогүй бол Б.Н.М.А.Улсын төмөр зам нь Б.Н.Х.А.Улсын төмөр замд захиалга авсанаас хойш 1 цагаас хожимдолгүй, локомотив өх бололцоогүй тухайгаа мэдэгднэ.

Б.Н.М.А.Улсын төмөр замын зөвшөөрөлтэйгээр Б.Н.М.А.Улсын төмөр замын галт тэрэгний локомотивуудыг, түүний бригадын хамт график ёсоор Эрлян станц дээр зогсох хугацаанд маневрын ажилд ашиглаж болох юм.

Маневрын ажил гүйцэтгэх байгаа станц нь галт тэрэг бүрдүүлэгч бригад гаргах өгнө.

§22. Нөгөө талын маневрын бууу галт тэрэгний

локомотивыг маневрын ажилд ашигласны хөлсийг 15 минут дугамаас 6,8 рублиэр тогтооно ; дутуу 15 минутыг гүйцэдээр бодож тооцно. Түүнээс гадна хилийн станцуудын хооронд хоёр тийш тусгай маневрын локомотив бэлтгэлээр явуулсны хөлсийг, локомотив шаардсан тал нь нөгөөдөө локомотив-гол-километр дутам 0,2 рублийг тэлнэ. / Хэрэв уурын тэрэг ажиллах байгаа бол төндрийн голыг тоолно /.

§23. Нөгөө талын локомотивыг маневрын ажилд ашигласан тухай тогтоосон маягт / 4-р хавсралт /-аар маневрын тасалбарыг станцийн дежурээс бичиж өгнө. Тасалбарыг 4 хувь бичиж хоёр этгээд тус бүр хоёр хувийг авна. Зориуд дуудах маневрын ажил хийлгэсэн локомотивын, ажилласан цагийг дуудсан станц дээр уг локомотив ирснээс эхлэн буцаж явах хүртэл тоолох болно.

Галт тэрэгний локомотивыг маневрын ажилд ашигласан цагийг уг локомотив жинхэнэ ажилласнаас эхлэн зогсох газартаа буюу галт тэрэгний бүрэлдэхүүндээ буцаж орох хүртэл тоолох болно.

#### Х. Хөдөлгөөний тасалдал.

§24. Хилийн станцууд дээр ба төдний хоорондын замд галт тэрэгнүүдийн хөдөлгөөнд элдэв бэрхшээлүүд ба тасалдал дохиолдвол нэг нь нөгөөдөө мэдэгдэнэ.

§25. Хилийн төмөр замуудын хэрэг эрхлэх газрууд нь галт тэрэгний хөдөлгөөний тасалдал,

эсгүүл ачаануудыг хүлээн авахыг хориглох, хязгаарлах шалтгаанууд, уг станц дээр галт тэрэг ба ачаануудыг бүрэн буюу хагасыг хүлээн авахыг хориглосон тухайг нэг нь нөгөөдөө телеграф юмуу бичгээр мэдэгдэнэ.

Ийм телеграммуудад галт тэрэг ба ачаануудыг хүлээн авах явдлыг бүрэн буюу хагасыг хориглох эхлэх он сар өдөр, тэрчлэн ачаануудыг хүлээн авах ба хэвийн хөдөлгөөнд барагцаалбал хэдийгээс оруулах зэргийг заасан байна.

§26. Галт тэрэгнүүдийн хөдөлгөөн ба ачаануудыг хүлээн авах явдлыг хориглосон болон хязгаарласныг бүрэн буюу хагасыг өөрчилсөн тухай он сар өдрийг зааж нэг нь нөгөөдөө телеграфар мэдэгдэнэ. Зохих арга хэмжээнүүдийг авхуулах зорилгоор эдгээр телеграммуудын хуулбарыг хоёр талын хилийн станцуудад явуулна.

Х I . Зохимол төхөөргүүд ба  
хөдлөх бүрэлдэхүүнийг  
засварлах болон зэхэх  
т у х а й .

---

§27. Хилийн станцуудын хооронд явж байгаа локомотивууд ба суудлын вагонуудыг эзэмшигч зам нь зохих хэмжээний түлш ба шаардагдах материалуудаар хангасан байвал зохино.

Аргагүй үед, нөгөө талын хилийн станц дээр хүрэлцэн ирсэн локомотивууд ба вагонуудид хэрэглэгдэх түлш ба туслах материалыг, зохих агентуудын бичмэл захиалгаар уг станц дээр тогтоогдсон журмаар

өөрийн өртгөөр олгоно.

§28. Нөгөө талын хилийн станц дээр хүлээн авах гэмтэлтэй вагонуудын байдал нь хөдөлгөөнд осол учруулж болох байвал хүлээн авагч тал тэнд нь засварлана. Ийм вагонуудыг эзэмшигч талын хилийн станцад өөрийн голоор яваа хүрч чадахаар засна.

Дурьдсан вагонуудын гэмтлүүдийг засварласан тухайд 6-р маягтаар протокол бичнэ.

Засварлахад бэрхшээлтэйгээр гэмтсэн вагонуудыг буцаах журмыг хоёр тал харилцан зөвлөж тогтооно.

2. Вагонуудын гэмтлийг зассаны зардлыг түүнийг гэмтэлд учруулсан тал хариуцна. Ачааны вагонуудыг засварласны үнийг 7-р хавсралтаар тогтооно. Суудлын вагонуудыг засварласны үнийг засварыг хийсэн тал нь өөрийн өртгөөр тогтооно.

3. Б.Н.М.А.Улсын төмөр замд гурав дахь улсын төмөр замд хамаарагдах, ачааны гэмтэлтэй вагонууд өргөж ирэх үед, вагонуудыг ашиглах дүрмийн / ВАД / 2-р бүлгийн 2-р зүйлийн 2-т заасан 2-р хавсралтын маягтаар акт табина.

§29. Хилийн хоёр станцийн хоорондох зам ба зохиомол төхөөрگیг хоёр этгээд тус тусдаа төмөр замын хил хүртэл / тусгаарлагч уулзуур хүртэл / арчлана. Тусгаарлагч уулзуурыг Б.Н.М.А.Улсын төмөр зам харж арчилж байна.

§30. Улсын хил дээр тавигдсан нийтийн хэрэгцээнд ашиглагдаж байгаа зохиомол төхөөр -

гүүдийг засварлах ба арчлах, төрчлөн сэргээн тэнхрүүлэх буюу барих явдлыг тусгай хэлэлцээрээр гүйцэтгэнэ.

ХП. Гэмтлийн үед ажиллах журам,  
Тэнхрүүлэх галт тэрэг ба  
цас цэвэрлэгч.

---

§31. Төмөр замын хилийн станцуудын хоорондын замд буюу станц дээр эсгүүл түүнтэй зэргэлдээ станцийн хоорондын замд галт тэргэнд осол тохиолдсон нь хөдөлгөөний график эвдэхээр байвал энэ тухай мэдэгдэл авсан станц нь нөгөө талын станцад бичгээр буюу телеграфаар мэдэгдэх үүрэгтэй.

§32. Хилийн станцуудын хоорондын замд галт тэрэг удаан хугацаагаар зогсох буюу осол эвдрэл гарсан үед ерөнхий кондуктор нь галт тэрэг зогсоох буюу осол эвдрэл аль талын нутаг дэвсгэрт гарсан бол, тэр талын хилийн станцад энэ тухай телефоноор буюу бие хүнээр дамжуулан бичгээр мэдэгднэ.

Ийм мэдэгдэл авсан станц нь, хилийн зэргэлдээ станцад телефон буюу телеграфаар яаралтай мэдэгдэж, галт тэргийг хоорондын замаас татан авч хөдөлгөөнийг сэргээх, тусламцаа үзүүлэх арга хэмжээ авах ба хэрэв шаардагдвал хилийн зэргэлдээ станцаас тусламж үзүүлэхийг хүснэ.

§33. Хилийн станцууд ба тэдгээрийн хоорондын замд осол эвдрэл тохиолдох үед хоёр этгээд, тэнхрүүлэх галт тэргээр харилцан туслах үүрэг авна.

Тэнхрүүлэх галт тэрэг ирүүлэх захиалгыг хилийн

станцийн даргад өгнө.

Бэртсэн хүнд эмнэлгийн тусламж хэрэгтэй эсэхийг энэ захиалганд заана.

§34. Тэнхрүүлэх галт тэргийг хилийн станцаас осол гарсан газар хүртэл түүнийг эзэмших төмөр замын төлөөлөгч хүргэнэ. Энэ төлөөлөгч нь тэнхрүүлэх галт тэрэгний хөдөлгөөнийг аюулаас хамгаалах хариуцлагыг хүлээнэ.

Осол тохиолдсон газар дээр тэнхрүүлэх галт тэрэгний дарга нь тэндэхийн ажлын удирдагчийн заалтаар ажиллана.

Осол гарсан газар дээр байгаа нөгөө талын төмөр замын хүмүүсийг хоёр талын төмөр замын төлөөлөгчдийн зөвшөөрөлцсөнөөр тэнхрүүлэх ажилд ашиглаж болох юм.

§35. Тэнхрүүлэх галт тэргийг ирүүлсэний зардлыг осол гаргасан буруутай этгээд нь хариуцна.

Энэ зардлыг, тэнхрүүлэх галт тэрэг улсын хил дээр ирснээс эхлэн, буцаж улсын хил хүсэний хоорондох хугацааг журналд бичснээр үндэслэн бодох гаргана.

Тэнхрүүлэх галт тэргийг ашиглаж эхэлсэн 30 минут дутмаас 40,6 рублийн хөлс авна. Бүрэн биш 30 минутыг бүрэнд тоолно.

Түүнээс гадна, тэнхрүүлэх галт тэргийг ашиглах хугацаанд, тэнхрүүлэх бригадын ажилласны жинхэнэ хөлс ба зарцуулагдсан материалуудын өртгийг төлнө.

§36.1. Хилийн станцуудын зам ба тэдгээрийн

хоорондох замыг цас цэвэрлэгчээр үйлчлэх явдлыг Б.Н.Х.А.Улс буюу Б.Н.М.А.Улсын төмөр зам хоорондоо тохиролцоо гүйцэтгэнэ.

2. Цас цэвэрлэгч шаардагдаж байгаа тухайг хилийн станцийн дарга нар хоорондоо телеграфаар мэдээлэлцнэ.

3. Цас цэвэрлэгч ашигласны тооцоог түүний ажиллаж эхэлсэн 30 минут бүрд 20,3 рублээр бодож үйлдэнэ. Бүрэн биш 30 минутыг бүрэнд тоолно.

Цас цэвэрлэгч ажиллаж эхэлснийг улсын хил дээр ирснээс тоолох ба ажиллаж дууссаныг буцаж улсын хил хүрснээр тоолно.

4. Улсын хилийг цас цэвэрлэгч нэвтрэн гарсан цагийг цас цэвэрлэгчийн журналд бичих бөгөөд түүний хуулбарыг хоёр талын төмөр замын агентууд гарын үсэг зурж батална.

### ХШ. Хүн тээвэрлэлт.

§37. Б.Н.М.А.Улс, Б.Н.Х.А.Улс хоёрын хооронд хоёр тийшээ хүн, тээш, бараа-тээш тээвэрлэхдээ:

1. Хэрэв тээвэрлэлтийг СМЖ-ийн тээврийн бичиг баримтуудаар эмхэлсэн бөгөөд олон улсын шууд харилцааны галт тэрэг буюу вагонд тээвэрлэх бол хүмүүсийг шилжүүлэн суулгах ба тээш, бараа-тээшийг шилжүүлэн ачих явдалгүй.

2. Хэрэв тээвэрлэлтийг СМЖ-ийн тээврийн бичиг баримтуудаар эмхэлсэн боловч Эрлян станцаас буюу Эрлян хүртэл Б.Н.М.А.Улс ба Б.Н.Х.А.Улсын галт тэргээр тээвэрлэх бол хүмүүсийг шилжүүлэн суулгах тээш, бараа- тээшийг шилжүүлэн авчна.

3. Үргэлж ба үргэлж биш харилцаанд явдаг олон улсын дууд харилцааны вагон ашигласны хөлсийг ВАД-ийн 1-р бүлгийн § 6-д зохицуулж төлнө.

§38. Олон улсын харилцааны галт тэрэг буюу вагонд эсгүүл Б.Н.М.А.Улс ба Б.Н.Х.А.Улсын төмөр замын нутгийн галт тэрэгний тээшийн вагонд СМПС-ийн тээвэрлэлтийн баримт бичгүүдээр, тээгдэх яваа тээш, бараа-тээшийг Б.Н.М.А.Улс, Б.Н.Х.А.Улс хоёрын төмөр замуудын хооронд хоёр тийшээ хилийн Эрлянц станц дээр шилжүүлэлцэхдээ СМПС-ийн албан зааврын §17-д заасан журмыг баримтлана.

§39. Хилийн станцуудын хооронд явж байгаа суудлын вагонуудыг техникийн талаар хүлээлцэхгүй.

Тийм вагонуудын хариуцлагыг олон улсын төмөр замын ачаа ба хүн тээврийн харилцааны /ВАД/ вагон ашиглах дүрмээр шийдвэрлэнэ.

§40. Хилийн станцуудын хоорондох замаар суудлын галт тэрэг өнгөрч байх үест вагонуудын хаалга цонх хаалттай байвал зохино. Энэ үест хүмүүс нь шилжих талбай ба тамбур дээр байж үл болно.

Х1Ү. Ачаа тээвэрлэлт, ачаануудыг хүлээлгэн өх ба хүлээн авах т у х а й .

§41. Б.Н.М.А.Улс, Б.Н.Х.А.Улс хоёрын хооронд хилийн станц-Замын-Үүд ба Эрляниар нэвтрүүлэн хоёр чиглэлд ачаа тээвэрлэхдээ Б.Н.Х.А.Улсын төмөр замын хүч хөрөнгөөр Зинин станц дээр ачааг шилжүүлэн ачих буюу ачаатай вагонуудыг өөр царигийн өргөнтэй

/ тэргэнцэр / хос дугуй дээр шилжүүлэн тавьх гүйцэтгэнэ.

Шилжүүлэн ачих, ачааг бэхлэх ба ачааны вагоныг хос дугуй дээр шилжүүлэн тавьсаны хөлсийг СМГС-ийн 13-р зүйл ба ЕТТ-ийн ҮШ-р бүлэгт заасан хэмжээгээр :

1/ Б.Н.М.А.Улсаас Б.Н.Х.А.Улсад очих буу эсрэг чиглэлд явах ачаа тээвэрлэх үест-очих станц дээр ачаа хүлээн авагчаас ;

2/ Б.Н.Х.А.Улсын төмөр замуудаар дайруулан ачаа тээвэрлэх үест-ачааг явуулагч буу хүлээн авагчийн хэнээс нь төмөр замаар нэвтрүүлэн тээвэрлэсний хөлсийг авсан бол түүнээс тус тус хураан авна.

§42. Нэг талын төмөр замаас нөгөө талын төмөр замд хоёр чиглэлд явж байгаа ачаа хүлээлцэх явдлыг Б.Н.Х.А.Улсын төмөр замын хилийн станц Эрлянэ дээр бүхэл жилийн турш өдөр бүр бүхэл хоногт гүйцэтгэнэ.

§43. Нэг этгээдийн төмөр замаас нөгөө этгээдийн төмөр замд ачаануудыг шилжүүлэхдээ олон улсын төмөр замын ачаа харилцааны /СМГС / хэрэгцээний албан заавар ба 1955 онд Улаан - Баатар хотноо хуралдсан Б.Н.М.А.Улс , Б.Н.Х. А.У, СССР гурвны төмөр замын төлөөлөгчдийн бага хурлаас гаргасан протоколд заасан журмуудыг баримтлана.

**ХҮ. Вагонуудыг хүлээлгэн өх**  
**ба хүлээн авах тухай .**

---

§44. Б.Н.М.А.Улсын төмөр замаас Б.Н.Х.А. Улсын төмөр зам ба эсрэг чиглэлд вагонуудыг хүлээлцэх явдлыг Б.Н.Х.А.Улсын төмөр замын хилийн станц Эрлянз дээр гүйцэтгэнэ.

§45. Хоёр талын төмөр замын агентууд вагонуудыг хүлээлцэх үедээ вагон ашиглах дүрэмд дурьдсан заалтуудыг удирдлага болгоно.

Хэрэв хүлээн авагч талын агентууд нь үзлэг хийхээр тогтоосон хугацаанд, үзлэг хийлгэхээр өгсөн вагонуудыг үзэх амжихгүй буруу үзлэг хийхээр ирэхгүй бол, тэдний үзлэг хийгээгүй бүх вагонуудыг техникийн талаар хүлээн авсан гэх үзнэ. Хүлээлгэн өх талын агентууд ирээгүй явдал нь хүлээн авалтыг зогсоохгүй.

§46, Техникийн үзлэг хийх хугацаанд хүлээн авч байгаа талын техникийн агент нь вагонуудад илэрсэн гэмтлийг өнө хөлөлцээрийн 5-р хавсралтын маягтаар гэмтлийн дэвтэрт бичнэ.

Дэвтрийн хуудас нэг бүрд нэг вагоны гэмтэл ба дутагдлыг хоёр хувь бичнэ.

Нэгдүгээр хувь нь вагонуудыг хүлээн авсан станцийн картотект хадгалагдах ба, хоёр хувь - дугаар хувь нь вагонуудын гэмтлийн дэвтэрт үлднэ.

Вагонуудыг буцаан хүлээлгэж өхөд нэгдүгээр хувийг станцийн картотекоос авч вагоны хуудсанд

хавсаргана.

Вагонуудыг буцаан хүлээлгэх өх үед илэрсэн гэмтлүүдийг, хүлээн авч байгаа талын агент нь анх шилжүүлэхэд бичсэнээс гадна, вагонуудын гэмтлийн тухай протоколд дурьдана. / Энэ хэлэлцээрийн 6-р хавсралт /.

Шилжүүлэх галт төрөг бүрд протоколыг 4 хувь үйлдэж тал тус бүр 2 хувийг авна.

5-р хавсралтын маягттай дэвтэр ба 6-р хавсралтын маягтаар бичигдсэн протоколд бичигдсэн вагонуудын гэмтлийг хоёр талын агентууд гарын үсэг зурж батлана.

§47. Вагонуудын гэмтлийг зассаны үнийг сэлбэг хэрэгслэлүүдийн үнэлэлтийн хүснэгтээр тогтооно. /Энэ хэлэлцээрийн 7-р хавсралт /.

Вагонуудыг шилжүүлэхдээ эзэмшигч-төмөр зам тус бүрийн вагонуудад тусад нь вагоны хуудсууд бичнэ.

§48. Вагонуудыг шилжүүлэх үзэлгт өгсөн цаг ба үзлэг хийж дууссан цагийг вагоны хуудсаны бүх хувьд хоёр талын агентууд, он сар өдөрт тэмдэг дарж батлана.

§49. Хоёр талын хилийн станцуудын дарга нар нь тайлант сарын эцсээр сарын дотор хүлээн авсан ба хүлээлгөн өгсөн вагонуудын төрөл ба тоо, тэрчлэн дараа сарын 1 ний Бээжингийн цагаар 17 цагт Б.Н.Х.А.Улсын төмөр зам дээр байгаа Б.Н,М.А.Улсын төмөр замын ба СССР-ийн төмөр

замуудын вагонуудын тооны тухай энэ хэлэлцээрийн 8-р хавсралтын маягтаар тайланг гаргаж хоёулаа хамтарч үсэг зурна.

§50. Шилжүүлэх галт тэрэгний вагонуудын хамгаалалтыг хүлээн авч байгаа замын агентууд бүрмөсөн хүлээн авах үе хүртэл хүлээлгэн өгч байгаа замын агентууд хариуцах үүрэгтэй.

Хүлээн авсан вагонуудын хамтаар нэгэн бүрэлдэхүүнд байгаа хүлээж аваагүй вагонуудыг, хүлээлгэн өгөгч замын агентад эгүүдэн шилжүүлэх хүртэл хүлээн авсан замын агент хамгаалж байх үүргийг хүлээнэ.

ХҮ1. Харилцан үйлчилсэний  
т о о ц о о.

§51. Энэ хэлэлцээрийг биелүүлэх явцад үүсч гарсан бүх тооцоонуудыг СМПС ба СМГС-үүдийн тооцоо үйлдэх дүрмээр шийдвэрлэнэ.

ХҮП. Хохирлыг хариуцах хоёр  
этгээдийн хариуцлага.

§52. 53-р зүйлд заагдсан хохирлын хариуцлагаас бусад хилийн станцуудын хооронд ба тэдгээр станцууд дээр тохжолдсон хохирол ба осолын хариуцлагыг эдгээр явдлууд гаргасан талын хууль дүрмүүдээр тогтооно.

§53.1. Тээвэрлэгдэх байгаа тээв, ачаа-тээв ба ачаануудыг гэмтээсэн, хүнд нь дутсан, бүрэн буку хагасыг үрэгдүүлсэн болон тэдгээрийг хүргэх өх хугацаа хожимдуулсаны хохирол

төлөх явдлыг олон улсын төмөр замын ачааны харилцааны /СМГЧ/ ба олон улсын төмөр замын суудлын харилцааны /СМПС/ хэлэлцээрүүдээр тогтооно.

2. Албан үүргээ гүйцэтгэх байгаа үест нөгөө талын төмөр замын агентуудад осол тохиолдох үед тэдэнд тэтгэвэр, тусламж олгох явдлыг тэр осолд учирагч нь аль улсын төмөр замын агент бол тэр улсын хуулиар тогтооно.

§54. Хилийн станцууд ба тэдний хоорондын замд гарсан эвдрэл ба бусад шалтгаануудаас тээш, бараа-тээш, ачаа, хөдлөх бүрэлдэхүүн, зам гэмтсэн зэрэг бусад бүх хохиролуудыг уг гэмтлийг учруулсан буруутай зам нь хариуцна.

Хэрэв гэмтэл нь хоёр талын буруугаас болсон буку учруулсан гэмтэлд хэн нь буруутай болохыг тогтоох бололцоогүй бол хариуцлагыг хоёр талын төмөр зам тэгш хүлээнэ.

§55.1. Хилийн станцууд ба эдгээрийн хоорондын замд төмөр замын төхөөргүүд, зам ба хөдлөх бүрэлдхүүн гэмтэлтэй байснаас болж үүссэн хохирол төлөх явдлыг уул төмөр замын төхөөргүүд, зам ба хөдлөх бүрэлдхүүнийг гэмтэлгүй арчилж байх үүрэгтэй тал нь хариуцна.

Вагонууд гэмтэлтэй байснаас учирсан хохирлын хариуцлагыг техникийн талаар сүүлчийн удаа хүлээн авсан агентуудын тал хүлээнэ.

2. Хохирлын хариуцлагыг нөгөө талд хүлээлгэх болох, гэмтэл бүрийг тэр талд яаралтай мэдэгдвэл зохино. Учирсан тохиолдлын шинжийг хянах, хохирлын хэмжээ ба хэн хариуцахыг хоёр талын хилийн төмөр замын хэрэг эрхлэх газруудын төлөөлөгчдөөс тогтооно.

3. Хэрэв хохирлыг тогтоох явдал нь шуудангийн буюу ачааны вагонд тээгдэж явсан шуудангийн ачаанд хамаарагдах бол уг асуудлыг хянахдаа, шууданг эрхлэх газрын төлөөлөгчийг оролцуулбал зохино.

§56. Хэрэв хохирол төлөх хариуцлагыг энэ хэлэлцээр ёсоор нөгөө тал нь бүрэн буюу хагасыг хүлээх ёстой бол заавал биелүүлэх шийдвэрээр төлсөн хохирлыг нэг тал нь нөгөө талаас буцаан шаардах эрхтэй.

§57. Хоорондын замд буюу хилийн станци дээр гэмтэл гарсан шалтгааныг хянах ба түүнээс үүссэн хохирлыг тогтоох явдлыг энэ гэмтэл тохиолдсон тал нь гүйцэтгэнэ.

Хяналтын явцын дүнд нөгөө тал нь хариуцах буюу хамтран хариуцах асуудал үүсэн гарвал энэ тухай нөгөө талдаа яаралтай мэдэгднэ. Цаашдын хяналтыг хоёр талын комиссуудаас хийж эцсийн хохирлыг тогтооно.

Нутагт нь гэмтэл тохиолдсон тал энэ комиссын зарлан хуралдуулна.

Зарлан хуралдуулсан тал комиссын даргална. Комисс нь эксперт дуудах эрхтэй байна.

Комиссууд асуудалд зөрөлцвөл хоёр талын хилийн төмөр замын хэрэг эрхлэх гаэрууд түүнийг шийдвэрлэнэ.

Хэрэв 3 хоногийн дотор нөгөө талын төлөөлөгчид ирэхгүй бол хянах явдлыг нэг тал нь гүйцэтгэнэ. Хяналтын дүн нь хоёр талд эцсийн шийдвэр болно.

Гэмтэл тохиолдсон газар дээр хийх сэргээн тэнхрүүлэх ажил нь комиссын ажлаас болж саадах ёсгүй.

§58. Хилийн станцууд дээр тэдний хоорондын замд хүн үхэх, ба гэмтэх, төмөр замын төхөөргүүд буюу тээвэрлэлтийн эд хогшил гэмтэх болон үрэгдэх явдал гарвал, мөрдөгдөж байгаа дүрмүүдийг биелүүлээгүйн гэрч болох учир зохих дүрмийг биелүүлээгүй тал нь харуцлагыг хүлээнэ.

§59. Байгалын аюулаас болж гарсан гэмтлийн, хохирлыг хоёр тал харуцахгүй.

ХҮШ. Албаны эд хогшил, материалууд,  
запас хэрэглэлүүд ба бичиг  
баримтуудын тээвэрлэлт .

---

§60. Нөгөө талын төмөр замын хилийн станцад явуулагдах хөдлөх бүрэлдхүүн, зам ба бусад төхөөргүүд засварлахад зориулсан материал ба сэлбэг хэрэглэлүүд, тэрчлэн албан ба тээвэрлэлтийн бусад бичиг баримтуудаас / тайлан, бланкууд, тарифын удирдамж / гаалийн ба бусад татвар хураалгүйгээр үнэ төлбөргүй тээвэрлэгднэ.

**XI X. Албан телеграммыг дамжуулах,  
телеграф ба телефоноор ярил-  
цах болон албан бичгүүдийг  
бичилцэх т у х а й .**

---

§61. СМПС ба СМПС-д оролцогчдын хооронд албан телеграммуудыг солилцох дүрэм ба хоёр талд мөрдөж байгаа, дотоодын дүрмүүдийн ёсоор албан телеграммуудыг төмөр замын байгууллагын нэрийн өмнөөс, түүнийг төлөөлсөн хүнийг гарын үсэгтэйгээр явуулна.

§62. Албан телеграммуудыг заавал, хилийн станцуудаар дамжуулан үнэ төлбөргүй явуулна.

§63. Хоёр талын төмөр замын станц нь заавал хилийн станцаар дамжуулан харилцна.

Албан телеграмм ба галт тэрэгний телеграмм, тэрчлэн хилийн станцуудын хоорондын албан бичиг баримтуудаас бусад бүх бичиг баримтуудыг дугтуйд хийж бичгүүлжээд үнийг төлж шуудангаар явуулна.

Хилийн станцуудын хооронд албан бичгээр, телефоноор албан яржамуудыг явуулах үед хоёр тал өөрийн албан ёсны хэлийг хэрэглэнэ.

**XX. Бичиг баримтуудыг орчуулах тухай.**

§64. Вагены хуудас, тээш, бараа-тээш, ачааг шилжүүлэх ба тээвэрлэх баримт бичгүүдийг, хүлээн авагч тал өөрийн улсын хэл дээр орчуулна.

Хоёр этгээд харилцан тохиролцож дурьдсан баримт бичгүүдийг, хүлээлгэн өгөгч тал орчуулж болно.

**XXI. Хилийн станцууд дээр бичиг  
баримтуудад гарын үсэг зурах  
т у х а й .**

---

§65. Протоколууд, актууд, вагоны ба шилжүүлэх хуудсууд, хоёр талын төмөр замын агентуудын хамтарсан ажиллагаагаар батлагдах ба тэрчлэн энэ бичиг баримтуудад засвар, тайлбар хийгдвэл хоёр талын төмөр замын зохих агентуудын гарын үсэг зурагдсан байвал зохियो.

Гарын үсэг зурхаас татгалзахыг зөвшөөрөхгүй, бичиг баримтуудын агуулгыг зөвшөөрөхгүй байгаа бол энэ тухай түүнд тэмдэглэл хийж гарын үсэг зурах ёстой.

Энэ хэлэлцээрт хавсрагдсан бүх бланкуудын мянгт нь монгол, орос, хятад гурван хэл дээр хэвлэгднэ.

Монгол тал нь бланкуудыг монгол бузу орос хэл дээр бөглөх бичнэ, харин хятадын тал нь өөрийнхөө хэл дээр бөглөх бичнэ.

**XXII. Хилийн холимог комиссын  
зарлан хуралдуулах тухай.**

---

§66. Хэлэлцээр бүхий талууд нь энэ хэлэлцээрийг биелүүлэхтэй холбогдсон асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хоёр талын төмөр замын төлөөлөгчдөөс бүрдсэн хилийн төмөр замын холимог комиссыг жилд хоёр удаа хоёр талдаа ээлжилж зарлан хуралдуулна.

Хилийн холимог комиссыг зарлан хуралдуулах ба ажиллагааны журмыг энэ хэлэлцээрийн 9-р хавсралтаар тогтооно.

УХШ. Энэ хэлэлцээрийн хугацаа ба үүнийг хүчин төгөлдөр бол -  
гох т у х а й.

§67. Энэ хэлэлцээр нь 1956 оны 1-р сарын 1 нээс эхлэн хүчин төгөлдөр болно.

Хэлэлцээр бүхий талууд нь харилцан ярилцах энэ хэлэлцээрт нэмэлт ба еөрчлөлт оруулж болно. Хилкийн төмөр замын хэлэлцээрт еөрчлөлт оруулах тухай асуудлыг олон улсын төмөр замын суудлын ба ачааны харилцааны хэлэлцээр / СМПС, СМГС /-ийг хэлэлцэх өөлжит бага хуралд буку албан бичгээр зөвшөөрөлцөн шийдвэрлэнэ.

§68. Хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулав.

Гэвч аль ч тал нь нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 6 сарын дараа хэлэлцээрээс татгалзаж болно.

§69. Энэ хэлэлцээрийг 1955 оны 10-р сарын 18 нд Улаанбаатар хотод монгол, хятад хоёр хэл дээр гарын үсэг зурсан ба хоёр эх нь адил хүчинтэй болно.

Эх бүрийг хоёр хувь үйлдэх гарын үсэг зурсан ба тал тус бүр нэг, нэг хувийг хүлээн авна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ  
АРД УЛСЫН ТЭЭВРИЙН ЯАМ-  
ЫГ ТӨЛӨӨДСӨН

*Цэцэгсүх*



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД  
АРД УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН  
ЯАМЫГ ТӨЛӨӨ

糜 鏞



**Хилийн төмөр замын холимог комиссын**

**Д Ү Р Ө М**

1. Хилийн төмөр замын хэлэлцээрийг биелүүлэх явдалтай холбогдсон асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хоёр этгээдийн төмөр замын төвийн байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан хилийн төмөр замын хэрэг эрхлэх газруудын төлөөлөгчдөөс бүрдсэн хилийн төмөр замын холимог комиссыг нэг жилд хоёр удаа зарлан хуралдуулна.

2. Хилийн төмөр замын хэрэг эрхлэх газрууд 60-аас доошгүй хоногийн өмнө харилцан тохиролцож хилийн төмөр замын холимог комиссыг зарлан хуралдуулах өдрийг урьдчилан тогтооно.

3. Хилийн төмөр замын холимог комиссыг, хилийн төмөр замын хэлэлцээрт оролцогч улсуудад зөвлөхөн хуралдуулна.

4. Хилийн төмөр замын холимог комисс нь хилийн төмөр замуудын үндсэн хэлэлцээрт өөрчлөлт оруулах шийдвэр гаргах үл болно.

5. Хэрэв хилийн төмөр замын холимог комисс хилийн төмөр замуудын хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах нь чухал гэж үзвэл уул хэлэлцээрт үсэг зурсаг хоёр талын төмөр замын төвийн байгууллагууд, хэлэлцээрийг шинэчлэн үзэх зохих өөрчлөлт нэмэлт оруулах тухай өөрийн протоколдоо санал болгоно.

Хилийн төмөр замуудын хэлэлцээрт үсгээ зурсан хоёр талын төмөр замын төвийн байгууллагууд дээрхи нэмэлт өөрчлөлтүүдийг харилцан зөвшөөрөлдөх тохиролцсоны дараа түүнийг хүдээн авч дагах мөрдсөнд тоолж болно.

6. Нутагт нь хилийн төмөр замын холимог комисс хуралдаж байгаа улсын төлөөлөгчдийн тэргүүн тэр хурлыг дэргэлна.

7. Нутагт нь хилийн төмөр замын холимог комисс хуралдах улс комиссын ахлын программыг боловсруулж нөгөө улсаа 30 хоногийн өмнө хүргүүднэ. Хурлын материалуудыг хэвлэх явдлыг комиссыг хуралдуулсан улс хангаж гүйцэтгэнэ.

8. Хилийн төмөр замын холимог комиссын протоколыг уул комисст оролцогч хоёр талын албан ёсны хэл дээр үйлдэж хэвлүүднэ. Улс тус бүр хоёр хэл дээр үйлдсэн комиссын протокол нэг, нэг хувийг авна.

9. Хилийн холимог комиссын шийдвэр хүчин төгөлдөр болох өдрийг энэ комиссын протоколд заана.